

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-6
<hr/>	
1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа	4-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, С.Ганбаатар, Ч.Ундрэм;

Чөлөөтэй: Х.Баттулга, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, А.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Э.Одбаяр, Б.Тулга;

Тасалсан: Д.Батбаяр, М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, Ц.Сандаг-Очир;

Хоцорсон: Б.Батцэцэг-02 минут, Г.Ганбаатар-07 минут, Д.Ганбат-07 минут, Д.Ганмаа-01 минут, Б.Жавхлан-05 минут, Б.Жаргалан-01 минут.

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн
ажиллагаа**

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж;

Зүүн хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт;

Зүүн урд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Дэд дарга Э.Лхагва, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хэвлэл мэдээллийн газрын дарга Э.Болортуяа, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул;

Урд талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга О.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Т.Төрболд, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх Т.Алтангэрэл, Б.Батзаяа, Н.Булгантамир;

Баруун урд талд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх нар суудлаа эзэлсэн байв.

Танхимын дээд давхарт Монгол Улсад суугаа гадаад орнуудын элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлт. 2024.10.01” гэсэн үг гарч байв.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв./10:19/

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн газрын Иргэд, олон нийттэй харилцах газрын студи, МҮОНРТ-ийн Монголын мэдээ суваг, Монгол кино нэгтгэл, eguur.mn, ergelt.mn, mpa.mn, news.mn, tas.mn, surag.mn, “Зууны мэдээ” сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын болон Улсын Их Хурал дахь Монгол Ардын нам, Ардчилсан намын бүлгүүдийн, мөн Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдын ажлын албаны, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтэс хариуцан ажиллав.

Хуралдаан 09 минут үргэлжилж, 126 гишүүнээс 111 гишүүн хүрэлцэн ирж, 88.1 хувийн ирцтэйгээр 10 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтган мэндчилье.

100 гишүүн ирснээр ирц 79,4 хувьтай байна. Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Үндсэн хуулийн цэцийн дарга, Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын болон Нийслэлийн удирдлагууд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар оролцож байна.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Хүндэт зочид, нийт ард иргэд ээ,

Улс төрийн тогтолцооны цогц өөрчлөлтийн үр дүнд байгуулагдсан шинэ парламентын бүрэлдэхүүн анхдугаар чуулганаар ард түмний сонголтын үр дүнг баталгаажуулан, Монгол Улсын Засгийн газрыг эмхлэн байгуулсан бол ээлжит бус чуулганаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн тодотгол зэрэг хэд хэдэн чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн билээ. Ээлжит чуулганы чөлөөт цагт Улсын Их Хурлын үйл ажиллагаа тасралтгүй өрнөж, Та бид ард иргэд, сонгогчидтойгоо уулзаж, санал бодлыг нь сонсож, Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, гадаад улсаас

Монгол Улсад суугаа Элчин сайдууд, олон улсын байгууллагын төлөөллүүдтэй уулзаж, парламентын бүлгэмүүдээ байгууллаа.

Энэ намрын чуулганаар бид эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож, улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нэг салбараас хамааралтай эдийн засгийн суурийг өргөжүүлж, солонгоруулах, дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах хууль, эрх зүйн шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

Учир нь манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд эерэг өөрчлөлтүүд гарч олон улсын үнэлгээний “Fitch Ratings” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B+” түвшинд хүргэж ахиуллаа. Бүс нутгийн улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт илүү байж, бидний хийсэн ажил, хүрсэн үр дүн энэхүү зээлжих зэрэглэлд нөлөөлж, орлогоо төрөлжүүлэх боломжийг нээж өглөө.

Хамтарсан Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хууль нь улс орны хөгжлийг шинэ шатанд гаргах, их бүтээн байгуулалтын эхлэлийг тавьж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг 10,000 ам.долларт хүргэх дунд хугацааны зорилтыг биелүүлэхэд мөн чиглэгдэж байна.

Иймд, намрын чуулганаар хэлэлцэх Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжууд нь ирэх 4 жилийн хөгжлийн ерөнхий хандлага, эдийн засгийн өсөлтийг тодорхойлох тул Улсын Их Хурлын зүгээс Засгийн газраас авч хэрэгжүүлэх мега төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын бодит хүрэх үр дүнг нарийвчлан судалж, өмнөх алдаа сургамжаа эргэн санаж, ирээдүйд болох эрсдэлийг урьдчилан тооцож, ул суурьтай хандах шаардлагатай байна.

Эрхэм гишүүд ээ,

Бидний гадаад орчинд, дэлхий дахинаа томоохон хүчнүүдийн геостратегийн өрсөлдөөн өрнөж, олон улсын харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлж байна.

Иймд, төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэхдээ гадаад хүчин зүйлсээр нөхцөлдүүлсэн эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван туулж, сэргэж байгаа эдийн засгийг цаашид тогтвортой хадгалж, иргэдийн бодит орлогыг хамгаалах асуудлыг онцгойлон анхаарах учиртай.

Та бид Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг хууль, эрх зүйн болон бодлогын гол бичиг баримтыг үндэс болгон, эх орныхоо язгуур эрх ашгийг дээдлэн, төр улсын хөгжилд хөтлөх асуудалд илүү няхуур хандах шаардлагатай байна.

Энэ цаг үед байгуулагдсан 5 намын төлөөлөл бүхий 126 гишүүнтэй парламентыг иргэдийн зүгээс илүү нээлттэй, ил тод байх, Улсын Их Хурлын гишүүний чиг үүргээ ажил хэрэгч, хариуцлагатай хандана гэсэн өндөр хүлээлт нийгэмд үүссэн байна.

Иймд, энэхүү хүлээлтэд хүрч ажиллахыг зорихоос гадна, хуучин сэтгэлгээнээсээ ангижирч, улс орны дотоод, гадаад бодлогыг тодорхойлох төрийн эрх барих дээд байгууллагын хувьд илүү шинэлэг, үр нөлөөтэй ажиллах хэрэгцээ шаардлага нийгмийн хөгжил, техник технологийн дэвшилтэй холбогдон гарч байна.

Өргөн мэдүүлсэн, баталсан хуулийн тоогоор ажлаа дүгнүүлж, сонгогчдодоо тайлагнахыг хичээдэг өрөөсгөл ойлголтоос салж, санаачилсан, батлуулсан хуулиудын нийгмийн амьдралыг зохицуулахад гүйцэтгэсэн

үүрэг, чанар, бодлогын залгамж байдлыг хэрхэн хангасан болон дэвшилтэд хөгжилд оруулсан бодит хувь нэмэр, үр дүнтэй нь холбон дүгнэдэг арга барилд шилжих цаг болсон.

Хууль бол иргэдийн амьдралд шахалт, дарамт биш харин амьдрал нь өөдөө дээшлэхэд дэмжин туслахад чиглэж байх учиртай. Тиймээс Улсын Их Хурлын даргын хувьд эргэх холбоотой парламентыг төлөвшүүлэх, хүн төвтэй хууль тогтоох ажиллагааг хөгжүүлж, хуулийг чанаржуулахад тууштай анхаарч ажиллана.

Монгол Улсын Их Хурал эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлж, Монголын ард түмний засаглах эрхийг хангах учиртай.

Улсын Их Хурлын даргын хувиар парламент бүрэн эрхийнхээ хугацаанд

“ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ” буюу хууль хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй үзэл санаа бүхий байх;

“ЦАГ ҮЕИЙН ШААРДЛАГАД НИЙЦСЭН ХУУЛЬ” буюу нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргадаг байх;

“ИЖ БҮРЭН ЗОХИЦУУЛАЛТТАЙ, ОЙЛГОМЖТОЙ ХУУЛЬ” буюу хуулийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлох гэсэн эрх зүйн орчны **“ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ”**-ийг санаачлан эхлүүлээд байна.

Бидний **“ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ”**-ийн зорилго хэрэгжих аваас, нийгэмд үүссэн авлига, хүнд суртал, хүний эрхийн зөрчил, тэгш бус байдлыг үндсээр нь халах болно.

Энэхүү зорилгыг бодит болгохын тулд хэрхэн ажиллах, ямар зорилт дэвшүүлэх тухай Улсын Их Хурлын

стратегу төлөвлөгөөнд баяжуулан тусгаж хэлэлцэхээр төлөвлөж байна.

Улмаар, Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 54 ажлын хэсэг ажилдаа эрчимтэй ороод байгааг дуулгахад таатай байна.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хууль, тогтоол батлах нэг хэрэг. Хууль хэрэгждэггүй бол тэр ердөө л тунхаг болдог. Иймд цаашид хуулийн чанарт онцгой анхаарал хандуулж, батлагдсан хууль тогтоомж хүн бүрд адил, тэгш үйлчилдэг, хэн нэгэнд зүй бус давуу байдал бий болгодоггүй, хүний эрхийг дээдэлсэн, тодорхой, ойлгомжтой байхад бид хичээх ёстой.

Улсын Их Хурлын гишүүд Та бүхэн олон нийт, ард иргэдийн өдөр тутмын амьдралд тулгамдаад байгаа асуудлыг жижиг гэлтгүй мэдэрч, хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн шийдвэрлэх талаар санал, санаачилгатай ажиллах шаардлагатай байна. Гэхдээ зөвхөн өнөөдрөөр сэтгэж, олон нийтийн дунд нэр олж авахын төлөө бус, ирээдүй хойч үеэ бодож, нийтийн хөрөнгө нөөцийг зөв тооцоолж, хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд ажилдаа бүрэн төвлөрч, ажиллах ёстой гэдгийг анхааруулъя.

Намрын ээлжит чуулганаар Та бүхэндээ Улсын Их Хурлын даргын хувьд, илүү мэргэжлийн бүтээлч байж, ил тод, нээлттэй, шинжлэх ухаанч хэлэлцүүлгийн үр дүнд цагаа олсон, бодитой, үр ашигтай бодлогыг дэвшүүлж, хяналт тавьж, дүгнэж чаддаг шинэ цагийн улс төрийн соёлын төлөө хамтран ажиллах цаг үе ирснийг дурдаж байсан.

Иймд, эвийг эрхэмлэж, эрх ашгийн эрэмбээ санаж, иргэдийнхээ хүлээлгэсэн итгэлийг зүтгэлээр хариулахын төлөө ёс зүй, хариуцлагыг эрхэмлэн, ажил хэрэгч, үр бүтээлтэй хамтран ажиллахыг Улсын

Их Хурлын эрхэм гишүүд, Засгийн газар, бүх шатны төрийн байгууллагууддаа уриалж байна.

Намрын чуулганы хугацаанд хэлэлцэх асуудалд нухацтай хандаж, Байнгын хорооны болон чуулганы үйл ажиллагаанд хариуцлагатай, идэвх санаачилгатай оролцохыг Та бүхнээс хүсье.

Намрын чуулганыг эхлэх энэ өдөр Олон Улсын ахмадын өдөр тохиож байна. Монгол Улсын тусгаар тогтнол, бүтээн байгуулалтын он жилүүдэд улс орон, үр хүүхдүүдийнхээ сайн сайхны төлөө хөдөлмөр зүтгэлээ зориулж, гавьяаны амралтдаа суугаа азай буурлууддаа Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна.

Төр улсынхаа түүшиг, түмэн олон залуусынхаа нөмөр нөөлөг болсон нийт ахмадууддаа эрүүл энх, урт удаан наслахын ерөөл өргөн дэвшүүлъя.

Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.

Төрийн дуулал эгшиглэв./10:18/

Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нээлтийн хуралдаан ийнхүү өндөрлөж байна. Өнөөдөр улс төрийн намын бүлгүүд, Байнгын хороо, ажлын хэсгийн хурлууд хуралдаж эхлэхээр байгаа. Нээлттэй хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

10.19 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ